



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, газрын гүний дулааныг ашиглан төвлөрсөн инженерийн дэд бүтцийн хангамжийг шийддэг технологийг нутагшуулсан туршлага судлах ажлаар Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбулганыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл 2 хоногийн хугацаатай албан томилолтоор ажиллуулсугай.

2. Гүйцэтгэх захирлын томилолтын удирдамжийг 1 дүгээр, томилолтын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Томилолтын зардлыг холбогдох журмын дагуу тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Томилолтоор ажилласан тухай тайланг томилолтоор ажиллаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.


5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Л.Амгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны
01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт



ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, газрын гүний дулааныг ашиглан төвлөрсөн инженерийн дэд бүтцийн хангамжийг шийддэг технологийг нутагшуулсан туршлага судлах, хэрэгжүүлж буй төслүүд дээр хөрөнгө оруулалт татах

Хоёр. Хугацаа: 2025.01.15-2025.01.17


Гурав. Хийгдэх ажил:

- “Синопек грин энерги” компаний бага гүний /200м/ болон гүний /2км/ газрын гүний дулааны системтэй танилцах;
- Туршлага судлах болон хамтран ажиллах боломжийн талаар санал солилцох ажлын уулзалт хийх;
- Бээжин хот дахь дулааны насосоор халаадаг барилгын хороололтой танилцах үйл ажиллагаанд оролцох

Дөрөв. Тайлан:

Томилолтоор ажилласан тухай тайланг ажлын 5 хоногт багтаан танилцуулах.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны
01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт



**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭБУЛГАНЫГ
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН БЭЭЖИН ХОТОД
АЖИЛЛУУЛАХ ТОМИЛОЛТЫН ТӨСӨВ**

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Томилолтын зардлын төсөв:

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Дүн /төг/	Тайлбар
1	Онгоцны тийз 2 талдаа (Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар) Economy class	1	2,713,600	2,713,600	Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалыг баримтлан гадаад томилолтын зардлыг тооцов.
2	Зам хоног /50\$/	2	50\$	342,610	
3	Зочид буудал /110\$/	2	110\$	753,742	
4	Аялалын даатгал 30,000	1	30,000	30,000	
	Нийт			3,839,952	

Жич: Монгол банкны 2025 оны 0 дүгээр сарын 13-ны өдрийн ханшаар тооцсон болно. 1ам.доллар = 3,426.10 төгрөг